



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

᠘᠒᠔᠖. ᠐ᠶ. ᠘᠕ № 18᠑  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

Г ХУТАГ-ӨНДӨР СУМЫН СОЁЛЫН Г  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д.ГАНЦОГТ  
ТАНАА

Төрийн аудитын газраас танай байгууллагын  
2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах  
аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 7,030.0 мянган төгрөгийн 2 албан  
шаардлага, 39,533.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж  
өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны  
06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн  
хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030294



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/145/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Tserenlhamg@audit.gov.mn](mailto:Tserenlhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт .....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант байр, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 188

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**ХУТАГ-ӨНДӨР СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д.ГАНЦОГТ  
ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогчийг ТҮ-8 цалингийн ангиллаар улиралд 40 хувиар цалинжуулж, хэмнэгдсэн цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан, Үндсэн хөрөнгийн тайланд 39205, 39214, 39305, 39207, 39201 дансанд 32 нэр төрлийн ашиглалтын хугацааг /-1, 0/ буруу тайлагнасан хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2005 оны 233 дугаар тушаалаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам-ыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Соёлын тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдаж 2022 оноос мөрдөж эхлэн, эрхлэгч, номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музейн ажилтны нийт 5 орон тоотойгоор сумын хүн амд соёл, урлагийн үйлчилгээг үзүүлсэн байна.

006020221

## **Аудитын гол асуудал**

Соёлын төвийн үлгэрчилсэн дүрэмд тусгагдаагүй, батлагдаагүй нягтлан бодогчийн орон тоогоор улирал бүр үндсэн цалингийн 40 хувиар цалинжуулан, цалингийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,445,100.00</b>	<b>10,825,124.86</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	380,024.86
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	380,024.86
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	380,024.86
31211	Төрийн сангийн харилцах	-	380,024.86
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	10,445,100.00	10,445,100.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,445,100.00	10,445,100.00
35420	Аж ахуйн материал	10,445,100.00	10,445,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>261,441,107.18</b>	<b>285,040,531.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	261,441,107.18	285,040,531.97
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	258,875,107.10	280,816,531.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	585,476,401.71	605,476,401.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(364,172,827.19)	(373,930,767.23)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,496,140.00	12,496,140.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,522,140.08)	(12,236,402.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,106,718.00	15,106,718.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,496,907.34)	(9,675,528.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,537,559.00	36,537,559.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,369,749.00)	(8,290,964.04)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2,390,000.00	2,390,000.00
39217	Ном	13,819,912.00	15,333,375.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,566,000.08	4,224,000.12
39301	Програм хангамж	220,000.00	1,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(43,999.92)	(65,999.88)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>271,886,207.18</b>	<b>295,865,656.83</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>713,935.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	713,935.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	713,935.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	713,935.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	713,935.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>271,172,272.18</b>	<b>295,865,656.83</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	271,172,272.18	295,865,656.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,515,463.37	94,515,463.37
51101	Өмч: - төрийн	94,515,463.37	94,515,463.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(108,383,209.82)	(83,689,825.17)
51210	Өмнөх үеийн үр дүн	(93,315,745.99)	(108,383,209.82)
51220	Тайлант үеийн үр дүн	(15,067,463.83)	24,693,384.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	285,040,018.63	285,040,018.63

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	271,886,207.18	295,865,656.83
---	--	----------------	----------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>107,893,500.00</b>	<b>160,578,680.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>500,000.00</b>	<b>37,435,463.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	500,000.00	37,435,463.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	37,435,463.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	1,422,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	36,013,463.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>107,393,500.00</b>	<b>123,143,217.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	102,393,500.00	123,143,217.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	102,393,500.00	123,143,217.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,000,000.00	-
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>121,616,520.79</b>	<b>135,885,295.35</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>121,616,520.79</b>	<b>135,885,295.35</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	121,215,765.79	135,117,295.35
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	52,204,535.00	63,120,617.20
210101	Үндсэн цалин	42,291,300.00	47,867,604.60
210102	Нэмэгдэл	9,913,235.00	9,161,081.00
210104	Урамшуулал	-	6,091,931.60
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,927,100.00	6,483,481.94
210201	Тэтгэврийн даатгал	4,867,500.00	4,039,413.94
210202	Тэтгэмжийн даатгал	514,900.00	678,041.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	411,900.00	484,276.59
210204	Ажилгүйдлийн даатгал	103,000.00	124,022.27
210205	Эрүүл мэндийн даатгал	1,029,800.00	1,157,727.84
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,504,800.00	41,065,321.00
210301	Гэрэл, цахилгаан	429,600.00	1,012,421.00
210302	Түлш, халаалт	40,075,200.00	40,052,900.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	324,995.00	483,000.00
210401	Бичиг хэрэг	59,995.00	110,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	50,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	53,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	270,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,080,000.00	1,390,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	1,100,000.00

210604	Урсгал засвар	1,000,000.00	290,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	58,000.00	58,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	58,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,199,650.00	5,422,337.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,899,650.00	5,422,337.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,916,685.79	17,094,038.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,916,685.79	14,594,038.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	400,755.00	768,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	308,000.00	768,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	308,000.00	768,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	92,755.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,755.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(13,723,020.79)</b>	<b>24,693,384.65</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,344,443.04	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,344,443.04	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(15,067,463.83)</b>	<b>24,693,384.65</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>107,985,900.00</b>	<b>124,565,217.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>592,400.00</b>	<b>1,422,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	592,400.00	1,422,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	1,422,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	1,422,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,400.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>107,393,500.00</b>	<b>123,143,217.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	102,393,500.00	123,143,217.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	102,393,500.00	123,143,217.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,000,000.00	-
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>102,985,900.00</b>	<b>122,005,192.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>102,985,900.00</b>	<b>122,005,192.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>102,585,145.00</b>	<b>121,237,192.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	51,490,600.00	62,633,067.65
210101	Үндсэн цалин	42,291,300.00	47,210,048.40

210102	Нэмэгдэл	9,199,300.00	9,331,087.65
210104	Урамшуулал	-	6,091,931.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,927,100.00</b>	<b>7,684,966.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,867,500.00	5,149,578.48
210202	Тэтгэмжийн даатгал	514,900.00	678,041.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	411,900.00	495,192.54
210204	Ажилгүйдлийн даатгал	103,000.00	124,022.27
210205	Эрүүл мэндийн даатгал	1,029,800.00	1,238,131.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,504,800.00</b>	<b>41,065,321.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	429,600.00	1,012,421.00
210302	Түлш, халаалт	40,075,200.00	40,052,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>324,995.00</b>	<b>483,000.00</b>
210401	Бичиг хэрэг	59,995.00	110,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	50,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	53,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	270,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,080,000.00</b>	<b>1,390,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	105,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	185,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>58,000.00</b>	<b>58,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	58,000.00	58,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,199,650.00</b>	<b>5,422,337.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,899,650.00	5,422,337.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>-</b>	<b>2,500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>400,755.00</b>	<b>768,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>308,000.00</b>	<b>768,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	308,000.00	768,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,755.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,000,000.00</b>	<b>380,024.86</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>2,180,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>2,180,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,000,000.00</b>	<b>2,180,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	5,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,180,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(2,180,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>380,024.86</b>

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	380,024.86
----	---	---	------------

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,515,463.37	285,040,018.63	(93,315,745.99)	286,239,736.01
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,515,463.37	285,040,018.63	(93,315,745.99)	286,239,736.01
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,067,463.83)	(15,067,463.83)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,515,463.37	285,040,018.63	(108,383,209.82)	271,172,272.18
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,515,463.37	285,040,018.63	(108,383,209.82)	271,172,272.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,515,463.37	285,040,018.63	(108,383,209.82)	271,172,272.18
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	24,693,384.65	24,693,384.65
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,515,463.37	285,040,018.63	(85,869,877.17)	293,685,604.83

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	127,906,700.00	124,185,192.14	3,721,507.86	97.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,906,700.00	124,185,192.14	3,721,507.86	97.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,906,700.00	124,185,192.14	3,721,507.86	97.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,764,900.00	62,633,067.65	131,832.35	99.79
210101	Үндсэн цалин	48,853,400.00	47,210,048.40	1,643,351.60	96.64
210102	Нэмэгдэл	10,731,600.00	9,331,087.65	1,400,512.35	86.95
210104	Урамшуулал	3,179,900.00	6,091,931.60	- 2,912,031.60	191.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,852,900.00	7,684,966.49	167,933.51	97.86
210201	Тэтгэврийн даатгал	5,222,400.00	5,149,578.48	72,821.52	98.61
210202	Тэтгэмжийн даатгал	740,400.00	678,041.30	62,358.70	91.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	509,100.00	495,192.54	13,907.46	97.27
210204	Ажилгүйдлийн даатгал	125,700.00	124,022.27	1,677.73	98.67
210205	Эрүүл мэндийн даатгал	1,255,300.00	1,238,131.90	17,168.10	98.63

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,097,200.00</b>	<b>41,065,321.00</b>	31,879.00	99.92
210301	Гэрэл, цахилгаан	1,022,000.00	1,012,421.00	<b>9,579.00</b>	99.06
210302	Түлш, халаалт	40,075,200.00	40,052,900.00	22,300.00	99.94
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,012,700.00</b>	<b>983,000.00</b>	29,700.00	97.07
210401	Бичиг хэрэг	60,000.00	110,000.00	- 50,000.00	183.33
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	50,000.00	<b>50,000.00</b>	50.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	53,000.00	22,000.00	70.67
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	277,700.00	270,000.00	<b>7,700.00</b>	97.23
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,100,000.00</b>	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	1,100,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	300,000.00	290,500.00	9,500.00	96.83
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>58,000.00</b>	<b>58,000.00</b>	-	100.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	58,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,160,000.00</b>	<b>7,102,337.00</b>	57,663.00	99.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,160,000.00	7,102,337.00	57,663.00	99.19
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,800,000.00</b>	<b>2,500,000.00</b>	3,300,000.00	43.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.00	2,500,000.00	3,300,000.00	43.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	768,000.00	768,000.00	-	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>768,000.00</b>	<b>768,000.00</b>	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00	-	100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	127,406,700.00	124,565,217.00	2,841,483.00	97.77
132001	Орон нутгийн төсвөөс	127,406,700.00	124,565,217.00	2,841,483.00	97.77
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	4,222,000.00	1,422,000.00	2,800,000.00	33.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,222,000.00	1,422,000.00	2,800,000.00	33.68
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	5	5	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансыг ашиглаагүй болно.

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Соёлын биет болон биет бус өв уламжлалыг өвлүүлэн түгээж, ардын уламжлал урлагийг орчин үеийн төрөл зүйлтэй хослуулан хөгжүүлж, эх хэл түүх соёлоороо бахархах, үндэсний өвөө өвлөн эзэмших, иргэнийг төлөвшүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэл дэмжин, соёлын боловсролыг дээшлүүлэн хөгжүүлэх гэж эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Зорилгоо хэрэгжүүлэхээр соёлын хэрэгцээг эрхэмлэн дээдэлж үнэт зүйлсээс суралцан, өвлөн уламжлан, бүтээж туурвин, зааж сурган түгээн дэлгэрүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Сумын түүх, соёлын өв, түүнийг өвлөн уламжлагч, хүн амын уламжлалт ёс заншил, зан үйл, байгаль цаг уур, бүтээн байгуулалтын онцлогтой холбоотой “Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, байнга баяжуулан, иргэдийн танин мэдэхүй, соёл урлагийн авьяас чадварын түвшнийг дээшлүүлэх үндсэн үйл ажиллагааг номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музейн ажилтан, нягтлан бодогч нийт 5 орон тоотойгоор төрийн үйлчилгээг үзүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь Соёлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын яамны бодлогын баримт бичиг батлагдаагүйгээс, Орон нутгийн байгууллагуудын мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна.

Соёлын Байгууллагын даргын баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 337,825.0 мянган төгрөгөөр буюу 57.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	380.0	380.0
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	10,445.1	10,445.1	-
Үндсэн хөрөнгө	261,441.1	285,040.5	23,599.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>271,886.2</b>	<b>295,865.6</b>	<b>23,979.4</b>
Өр төлбөр	713.9	-	(713.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	271,172.3	295,865.6	24,693.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>271,886.2</b>	<b>295,865.6</b>	<b>23,979.4</b>

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгийн данс өссөн байна.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны А/472 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 20,000.0 мянган төгрөгийн их засвар, өмнөх онд хийгдсэн Соёлын төвийн номын сангийн баяжуулан бэлтгэсэн 1,500.0 мянган төгрөгийн номыг нөхөж орлогод авсан, тайлант онд 1,680.0 программ хангамж, 500.0 мянган төгрөгөөр номын сангийн номыг баяжуулан ном худалдан авсан нь үндсэн хөрөнгө өсөхөд нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 188,393.7 мянга, өөрийн орлогоос 500.0 мянган төгрөг нийт 188,893.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 60,986.9 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөс 120,906.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийг тодотгоогүй байна. 2022 онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 127,906.8 мянган төгрөгийг улсын төсвөөс

бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улс болон орон нутгийн төсвөөс 124,565.2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 1,422.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 124,565.2 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3,341.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Соёл урлагийн газрын санхүүжилтийг номын сангийн номын баяжилтад 500.0 мянга, программ хангамжид 1,680.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	код	арга хэмжээ				
Нийт дүн			127,906.8	124,565.2	3,341.6	97.4
1	70702	80101	75,477.1	75,477.1	-	100.0
2		80214	3,000.0	3,000.0	-	100.0
3		80802	768.0	768.0	-	100.0
4		83603	4,722.1	1,422.0	3,300.1	30.1
5		80111	40,975.2	40,933.8	41.4	99.9
6		80112	2,964.4	2,964.3	0.1	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 127,406.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,911.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,433.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5-д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс бүх мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 13 дугаар албан тоотоор ирүүлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,000.0	1	5,000.0	100.0
Зөвлөмж	2	713.9	2	713.9	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>5,713.9</b>	<b>3</b>	<b>5,713.9</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,815.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 17,815.7 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайлангийн зардлыг дутуу тайлагнасан дүнг залруулсан.

Аудитаар нийт 46,563.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 7,030.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 39,533.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

1. Соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогчийг цалингийн ангилал /ТҮ-8/-аар тооцож улирал тутамд 40 хувиар цалинжуулж, хэмнэгдсэн цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалаар баталсан "сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 7-д "Соёлын төвийн номын санч-мэдээллийн ажилтан, дуу хөгжим, бүжгийн багш, музей /орон нутаг сурталчлах танхим/-н ажилтныг сумын Засаг даргын тамгын газартай зөвшилцөн Соёлын төвийн эрхлэгч томилж, чөлөөлнө" гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоож, зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргах байх албан шаардлага өгөх.

2. Тооцоолсон цалингаар цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэн тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.60 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС-ын дагуу бүртгэл тайлагналыг хөтөлж, гаргасан алдаа зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргах байх албан шаардлага өгөх.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн тайланд 39205, 39214, 39305, 39207, 39201 дансанд 32 нэр төрлийн ашиглалтын хугацааг /-1, 0/ буруу тайлагнасан хөрөнгө бүртгэлтэй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Сангийн сайдын элэгдэл тооцох журмыг баримтлан, үнэн зөв тооцож, ашиглалтын хугацааг үнэн зөв бүртгэж, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого үр дүнгийн тайлангийн зардлыг дутуу тайлагнасан байна.	1	17,815.8	-	-	1	17,815.8	1	17,815.8	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>17,815.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>17,815.8</b>	<b>1</b>	<b>17,815.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооцоолсон цалингаар цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар НДШ, ХХОАТ, бусад өглөгийг бүртгэсэн.	1	6,072.8	-	-	1	6,072.8	-	-	-	-	-	-
Соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогчийг ТҮ-8 цалингийн ангиллаар /797676 төгрөг/ улиралд 40 хувиар цалинжуулж, жэмнэгдсэн цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан.	1	957.2	-	-	1	957.2	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн тайланд 39205, 39214, 39305, 39207, 39201 дансанд 32 нэр төрлийн ашиглалтын хугацааг /-1, 0/ буруу тайлагнасан хөрөнгө бүртгэлтэй байна.	1	39,533.4	-	-	-	-	1	39,533.4	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>46,563.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>7,030.0</b>	<b>1</b>	<b>39,533.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй.								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Байхгүй.								
Дүн								
Нийт дүн								



БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 01/91  
А0670053 БУА-2023/84/НА-СТА-ТМЗ Булган сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардалд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд нягтлан бодогчийн орон тоо батлагдаагүй байхад Соёлын төвийн эрхлэгчийн 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогчид ТҮ-8 цалингийн ангиллаар улиралд 40 хувиар цалинжуулж, хэмнэгдсэн зардлаас 957,211.00 (есөн зуун тавин долоон мянга хоёр зуун арван нэг) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалаар баталсан "Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 7 дахь заалтыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй хэмнэгдсэн зардлаас 957,211.00 (есөн зуун тавин долоон мянга хоёр зуун арван нэг) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан алдаа зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хутаг-Өндөр сумын сумын Соёлын төвийн эрхлэгч (Д.Ганцогт), нягтлан бодогч (Н.Мягмаржаргал) нарт даалгав.

006040284

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

~~Б.ЭРДЭНЭ~~

АУДИТЫН МЕНЕЖЕР

~~Ж.ЭНХЦООДОЛ~~

АУДИТОР

~~Г.ЦЭРЭНЛХАМ~~

*S. Kozom*



6317144798  
ГЮА0048 3190269



БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 02/156

Булган сум

А0670253

ЗУА - 2023/145/НА - ЦТА - ТМЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардалд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд 6,072,816.55 (зургаан сая далан хоёр мянга найман зуун арван зургаан төгрөг тавин тав) төгрөгийн НДШ, ХХОАТ, бусад өглөгийг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Аймгийн Засаг даргын 2022 оны А/424 дүгээр захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. УСНББОУС-ыг хэрэгжүүлэн цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бичилт хийсэн алдаа зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хутаг-Өндөр сумын сумын Соёлын төвийн эрхлэгч (Д.Ганцогт), нягтлан бодогч (Н.Мягмаржаргал) нарт даалгав.

006040372

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ~~Б. ЭРДЭНЭ~~  
АУДИТЫН МЕНЕЖЕР ~~Ж. ЭНХЦООДОЛ~~  
АУДИТОР ~~Г. ЦЭРЭНЛХАМ~~

*Т. Казан*



6317144798  
ПОА0048 3190269